



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 4/408

Улаанбаатар хот

Журам, зөвлөлийн бүрэлдэхүүн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан, оношийг баталгаажуулах үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр, “Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоогдсон эсэхийг тодорхойлох зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал, “Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоогдсон эсэхийг тодорхойлох зөвлөл”-д тус тус даалгасугай.

3. Коронавируст халдварын үед эмгэг судлалын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн журам, зааврыг боловсруулах, хэрэгжилтийг хангах, судалгаа хийх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн яамны эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Э.Баярмаа), Эмгэг судлалын үндэсний төв (Г.Уянга) нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буянтогтох)-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141212087

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07
сарын 13-өдрийн 403 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



**“Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдлын
үхлийн шалтгаан, оношийг баталгаажуулах үйл ажиллагааны журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалд үндэслэн халдварын тохиолдлын эмнэлзүйн эмгэг судлалын конференцийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, бүртгэл мэдээллийн үнэн бодит мэдээллийг гаргах зорилгоор коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоогдсон эсэхийг тодорхойлох зорилгоор зөвлөл (цаашид зөвлөл гэх)-ийг байгуулан ажиллуулах шаардлагатай байна.

1.2 Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдлын үндсэн болон дагалдах өвчний оношийг хэлэлцэж, үхлийн шалтгааныг тодорхойлж, оношийг баталгаажуулах, мэдээлэх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.3 Хууль дээдлэх, хүний эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хараат бус байх, нууцыг хадгалах, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргах зарчмыг баримтална.

1.4 Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан, оношийг баталгаажуулах үйл ажиллагааг 72 цагт багтаан зохион байгуулна.

ХОЁР. Эмнэлэгт нас барсан коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан, оношийг баталгаажуулах, мэдээлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг:

2.1.1. Эрүүл мэндийн байгууллагууд эмнэлэгт коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдол бүрийг 24 цагт багтаан зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

2.1.2. Нас барсан тохиолдыг өдөр бүрийн 09:00-18:00 цагийн хооронд зөвлөлийн ахлагч Э.Баярмаа, нарийн бичиг Э.Ундармаатай утсаар холбогдон мэдэгдэнэ.

2.1.3. Нас барсан тохиолдлын өвчний түүх, үндсэн ба дагалдах оношийн үндэслэлийг танилцуулга хэлбэрээр бэлтгэж, тухайн эмнэлгийн

эмчилгээ эрхэлсэн орлогч болон эмчлэгч эмч, эмгэг судлаачийн бүрэлдэхүүнтэй баг зөвлөлд 5-7 минутанд багтаан танилцуулна.

2.1.4. Хамтарсан хэлэлцүүлгээс гаргасан дүгнэлтэнд үндэслэн оношийг баталгаажуулна.

2.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан, оношийг баталгаажуулах зөвлөлийн үүрэг:

2.2.1. Зөвлөлийн ахлагч, нарийн бичиг нар эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн газраас коференцийн хүсэлт ирүүлсэнээс хойш 24 цагийн дотор зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилж, хурлыг зохион байгуулна.

2.2.2. Зөвлөл эрүүл мэндийн байгууллагаас мэдэгдсэн нас баралтын тохиолдол бүрийг хэлэлцэхдээ 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй цахим платформыг ашиглан хуралдана.

2.2.3. Шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/217 дугаар тушаалаар батлагдсан үндэсний зөвлөх багаас эмнэлзүйн зөвлөхийг нэмэлт гишүүнээр хуралд оролцуулж болно.

2.2.4. Хурлын тэмдэглэлийг цахим хэлбэрээр архив үүсгэн хадгалах ба хэлэлцүүлсэн тохиолдолын бүртгэлийг хөтөлнө.

2.2.5. Зөвлөл нь эрүүл мэндийн байгууллагаас танилцуулж байгаа мэдээлэл болон өвчний түүх дээр үндэслэн коронавируст халдвар (КОВИД19)-аар өвчилж, нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан, үндсэн болон дагалдах өвчний оношийг эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэлэлцэж дүгнэлт гаргана.

2.2.6. Зөвлөл нь Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад нас баралтыг нөхцөл байдлын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хийх санал хүсэлтийг гаргана.

2.2.7. Зөвлөл хэлэлцүүлсэн тохиолдлын талаарх тайланг долоо хоног бүрийн пүрэв гаригаар тасалбар болгон баасан гарагийн 12 цагаас өмнө Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

Гурав. Гэртээ нас барсан коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан, оношийг баталгаажуулах, мэдээлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үүрэг:


3.1.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь тухайн нутаг дэвсгэрийн хүн амын дундах коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, гэртээ нас барсан тохиолдол бүрийг 24 цагт багтаан зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

- 3.1.2. Нас барсан тохиолдлыг өдөр бүрийн 09:00-18:00 цагийн хооронд зөвлөлийн ахлагч Э.Баярмаа, нарийн бичиг Э.Ундармаа нарт утсаар холбогдон мэдэгдэнэ.
- 3.1.3. Нас барсан тохиолдлын өвчний түүх, үндсэн ба дагалдах оношийн талаарх танилцуулга мэдээллийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан эсвэл нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч дарга, анхан шатны тусламж хариуцсан мэргэжилтний бүрэлдэхүүнтэй 5-7 минутад багтаан танилцуулна.
- 3.1.4. Хамтарсан хэлэлцүүлгээс гаргасан дүгнэлтэнд үндэслэн оношийг баталгаажуулна.

Дөрөв. Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж, нас барсан тохиолдлыг бүртгэх мэдээллийн урсгал

- 4.1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллага зөвлөлөөр хэлэлцүүлж, үхлийн шалтгаан коронавируст халдвар гэж тогтоогдсон тохиолдлыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд мэдээлнэ.
- 4.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв зөвлөлөөр хэлэлцүүлж, хамтын шийдвэр гаргаагүй нас баралтын тохиолдлыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын нэгдсэн бүртгэлд оруулахгүй.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 18 ны өдрийн 143 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоогдсон эсэхийг тодорхойлох зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн ахлагч

Э.Баярмаа, Эрүүл мэндийн яамны Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Био анагаахын сургуулийн Эмгэг судлал, Шүүх эмнэлгийн тэнхимийн эрхлэгч, АУ-ны доктор, профессор
Утас:99077847

Зөвлөлийн нарийн бичиг

Э.Ундармаа, Эмгэг судлалын үндэсний төвийн эмгэг судлалын тусламж, үйлчилгээний албаны дарга, тэргүүлэх зэрэгтэй эмгэг судлаач эмч
Утас:99148027

Зөвлөлийн гишүүд

Г.Уянга, Эмгэг судлалын үндэсний төвийн захирал, АУ-ны доктор, клиникийн профессор

Ш.Энхтуяа, Эрүүл мэндийн яамны Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, МУ-ын хүний гавьяат эмч, АУ-ны доктор, клиникийн профессор, зөвлөх зэрэгтэй эмгэг судлаач эмч

Б.Уранчимэг, Эрүүл мэндийн яамны Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, МУ-ын хүний гавьяат эмч, АУ-ны магистр, клиникийн профессор, зөвлөх зэрэгтэй эмгэг судлаач эмч

Б.Оюун-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, МУ-ын хүний гавьяат эмч, АУ-ны магистр, зөвлөх зэрэгтэй эмгэг судлаач эмч, эмгэг судлалын профессор

М.Наранпүрэв, Эрүүл мэндийн яамны Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар

зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, АУ-ны доктор

Б.Туул, Эрүүл мэндийн яамны Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, АУ-ны магистр, зөвлөх зэрэгтэй эмгэг судлаач эмч, эмгэг судлалын профессор

О.Энхээ, Эмгэг судлалын үндэсний төвийн насанд хүрэгсдийн эмгэг судлалын тасгийн эмгэг судлаач эмч, АУ-ны доктор

Г.Ганхүү, Эмгэг судлалын үндэсний төвийн Хүүхдийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч, АУ-ны магистр

Ж.Цэнгэлмаа, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Био анагаахын сургуулийн Эмгэг судлал, Шүүх эмнэлгийн тэнхмийн багш, АУ-ны доктор, эмгэг судлаач эмч

М.Ууганчимэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тасгийн эмч